



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 05 сарын 07 өдөр

Дугаар А/257

Эрдэнэт

Улсын Онцгой комиссын шийдвэрийг хэрэгжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5 "а", 29.1.5 "в", 29.1.6 "л", 29.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1, 11.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3.2, 32 дугаар зүйлийн 32.1, Архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 16 дугаар зүйлийн 16.1, Коронавируст халдвар (Ковид-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 104, 115, 118 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2021 оны 31, 41 дүгээр тушаал, 2021 оны 03 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Улсын хэмжээнд бүх нийтийн бэлэн байдлын зэргийг бууруулж өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж байгаатай холбогдуулан аймгийн хэмжээнд аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн үйл ажиллагааг 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсүгэй.

1.1. Орхон аймагт ирэх, аймгаас гарах зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 05 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд түр хязгаарласугай.

1.2. Баян-Өндөр, Жаргалант сумдын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйл ажиллагааг 2021 оны 05 дугаар сарын 08-ны өдрөөс 05 дугаар сарын 21-ний өдрийг дуустал хугацаанд түр хориглосугай.

1.3. Дээрх хугацаанд төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрсөн үйл ажиллагааг нэгдүгээр, хязгаарласан үйл ажиллагааг хоёрдугаар, хүн амыг Ковид-19 халдварын эсрэг дархлаажуулах ажлын зохион байгуулалтад дэмжлэг үзүүлэх, хяналт тавих ажлыг хариуцан зохион байгуулах албан тушаалтнуудын хуваарийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

1.4.Байгууллагууд ctr.erdenetmc.mn сайтыг ашиглан гэрийн ажиглалтад байгаа иргэдэд үйлчлэхгүй байх ажлыг зохион байгуулах, байгууллагынхаа өрөө тасалгаа, байр, орон сууцны орц, хонгил, цонх, хаалга, цахилгаан шат, нийтийн тээврийн хэрэгслийн хаалга, суудал, бариул, нийтийн эзэмшлийн гудамж, зам талбай, хүүхдийн тоглоомын талбайн ариутгал халдваргүйтгэлийн ажлыг үе шаттай зохион байгуулах, ажлын байранд ажилтны 30.0 хувиас хэтрүүлэхгүй байх, нэг дор 10-аас дээш хүн цугларах, нэг өрөөнд 3-аас илүү албан хаагч хамт ажиллахгүй байх, өдөр бүр ариутгал халдваргүйтгэл хийж, халдвар хамгааллын дэглэмийг чанд сахиулахыг Шуурхай штаб (Г.Ганбаатар), Эрдэнэт хотын Захирагчийн алба (С.Ганцогт), Хот тохижуулах газар (Б.Оюунбаяр), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа)-д болон төр, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагын удирдлагуудад даалгасугай.

2.Энэхүү захирамжийг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож ажиллахыг Онцгой байдлын газар (Г.Ганбаатар), Цагдаагийн газар (С.Цэрэнсамбуу), Мэргэжлийн хяналтын газар (Б.Жигдэнгомбо), Авто тээврийн төв (Г.Ядмаа), Баян-Өндөр сум (Б.Баасансүрэн), Жаргалант сум (Б.Зоригтбаяр)-нд үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Нийгмийн хөгжлийн асуудал хариуцсан орлогч А.Түвшинжаргал, аймгийн Засаг даргын орлогч М.Түмэнжаргал, Онцгой байдлын газрын дарга, хурандаа Г.Ганбаатар нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ

Аймгийн Засаг даргын 2021 оны 05
дугаар сарын 07-ны өдрийн А/258
дугаар захирамжийн I хавсралт


ЗӨВШӨӨРӨГДСӨН ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Эрчим хүч, дулаан, усан хангамж
2. Эрүүл мэндийн байгууллага, эмийн сан, эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх байгууллага
3. Шүүх, өмгөөлөл, нотариат
4. Шатахуун, түлшний хангамж
5. Хүнс, ахуйн хэрэглээний үйлдвэрлэл, худалдаа тээвэрлэлт, түгээлт, ханган нийлүүлэлт
6. Ариутгал, халдваргүйжүүлэлт, хог хаягдлын цэвэрлэгээ, ачилт, тээвэрлэлт
7. Банк, санхүүгийн байгууллага
8. Газар тариалан, өвс тэжээл, түлшний үйлдвэрлэл, нийлүүлэлт, түгээлт, тээвэрлэлт, худалдаа
9. Харилцаа холбоо, шуудан илгээмж
10. Улсын онц чухал болон стратегийн ач холбогдол бүхий объект, тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааг тасралтгүй хангах аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаа
11. Хэвлэл мэдээлэл
12. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлтэй харуул хамгаалалтын байгууллага
13. Геологи хайгуул, уул уурхай
14. Орон сууц, нийтийн үйлчилгээ, сууц өмчлөгчдийн холбоо
15. Буяны үйл ажиллагаа
16. Бүтээн байгуулалт, барилга байгууламж, барилгын материалын үйлдвэрлэл худалдаа
17. Хүнс, барааны худалдаа
18. Нийтийн хоолны захиалгат хүргэлтийн үйлчилгээ
19. Үсчин, гоо сайхан нийтийн ахуй үйлчилгээ (цаг олгож үйлчлэх, үйлчлүүлэгч хооронд хугацаа гаргаж халдваргүйтгэл хийх)
20. Нийтийн тээврийн болон такси үйлчилгээ (1 суудал алгасан 1 зорчигч суулгах)
21. Хувийн тээврийн хэрэгсэл хөдөлгөөнд оролцох (06.00-22.00)

Жич: Хязгаарлах үйл ажиллагааны жагсаалтад ороогүй тохиолдолд зөвшөөрсөнд тооцно.

- Үйл ажиллагаа нь зөвшөөрөгдөж буй байгууллага, аж ахуйн нэгжүүдийн ажиллагсад нь дархлаажуулалтын бүрэн тунд хамрагдсан байх

Аймгийн Засаг даргын 2021 оны 05
дугаар сарын 07-ны өдрийн А/258
дугаар захирамжийн II хавсралт



ХЯЗГААРЛАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

1. Хот хоорондын зорчигч тээврийн хэрэгсэл
2. Хүнсний дэлгүүр (6, 8 нэрийн) оройн 20.00 цагаас өглөөний 08.00 цаг хүртэл
3. Баян-Өндөр, Жаргалант сумдын хэмжээнд архи согтууруулах ундаа худалдан борлуулах, түүгээр үйлчлэх үйл ажиллагаа
4. Бага насны хүүхдийг асран хамгаалагчгүйгээр гадуур явуулах
5. Бүх төрлийн нийтийн хоолны заалны үйлчилгээ
6. Олон нийтийг хамарсан арга хэмжээ жагсаал, цуглаан
7. Спортын арга хэмжээ, уралдаан тэмцээн, аялал зугаалга, хурим найр, цайллага, хүлээн авалт
8. Баар (паб, диско, караоке)
9. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа
10. Цахим болон бүх төрлийн тоглоомын газар
11. Танхимын болон үйлдвэрлэлийн сургалт
12. Үзвэр үйлчилгээ, нийтийн бүжиг, соёл урлаг (цахимаар болон зайнаас зохион байгуулахаас бусад)
13. Чийрэгжүүлэх, бялдаржуулах, алжаал тайлах төв, саун бассейн
14. Зочид буудал, дэн буудал, амралтын газар
15. Сүм хийдийн цугларалт, уншлага

00

Аймгийн Засаг даргын 2021 оны 05
дугаар сарын 07-ны өдрийн А/257
дугаар захирамжийн III хавсралт

ХҮН АМЫГ КОВИД-19 ХАЛДВАРЫН ЭСРЭГ ДАРХЛААЖУУЛАХ
АЖЛЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ДЭМЖЛЭГ ҮЗҮҮЛЭХ, ХЯНАЛТ ТАВИХ
АЖЛЫГ ХАРИУЦАН ЗОХИОН БАЙГУУЛАХ АЛБАН ТУШААЛТНУУДЫН ХУВААРЬ

д/д	Өрхийн эмнэлгийн нэр	Байрлал	Байгууллагын дарга
1	Анхны оч	4 дүгээр сургууль	Мэдээлэл холбооны сүлжээ компани ТӨХК-ийн захирал Г.Эрдэнэбат
2		Спорт хороо А заал	Эрдэнэт Булганы ЦТС ТӨХК-ийн захирал В.Адъяа
3	Учралтбаяр	7 дугаар сургууль	Нийгмийн даатгалын хэлтсийн дарга Б.Анар
4		Эрдэнэ баг Соёлын төв	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын дарга хурандаа М.Ариунболд
5	Мэндцэцэн	7 дугаар цэцэрлэг	Шуудан үйлчилгээний газрын дарга Ц.Алтаншагай
6		4 дүгээр цэцэрлэг	Хот байгуулалт, барилга захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын дарга Ц.Баяржаргал
7	Мөнхийн гэгээ	17 дугаар сургууль	Боловсрол, соёл урлагийн газрын дарга О.Ариунгэрэлт
8	Энхжихмандарваа	15 дугаар сургууль	Цэцэрлэгжүүлэлт ногоон байгууламж УТҮГ-ын дарга Х.Оюун-Эрдэнэ
9	Нийцэл	16 дугаар сургууль	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газрын дарга Х.Эрдэнэбат
10	Мөнхсүндрэл	2 дугаар сургууль	Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн захирагч хурандаа Д.Жигжидсүрэн
11		Баянцагаан баг Соёлын төв	Орхон АЗЗА ТӨХК-ийн захирал Ц.Батзориг
12	Үйлсбадрах	3 дугаар сургууль 1 дүгээр байр	Баян-Өндөр сумын ИТХ-ын дарга Э.Эрдэнэбат
13		3 дугаар сургууль 2 дугаар байр	Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрын дарга А.Наранболд
14	Жаргалант сум	Ерөнхий боловсролын сургууль	Жаргалант сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал Д.Нямдаваа
15		Соёл мэдээллийн төв	Соёлын төвийн эрхлэгч Б.Оюунгэрэл
16	Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ	Хангарьд спорт ордонд 5 баг	"Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Нийгмийн хөгжлийн харилцааны хэлтсийн орлогч дарга Д.Эрдэнэбат

Зохион байгуулах ажлын чиглэл:

- Дархлаажуулалтын байрны бэлтгэл ажлыг шалгаж, бэлэн байдлыг хангуулах.
- Багийн иргэдийг вакцинд хамруулах талаар ухуулга сурталчилгаа, уриалгыг сум, багтай хамтран зохион байгуулах.
- Шуурхай штабаас өгсөн чиглэлийн дагуу өглөө 08.00 цагаас орой 21.00 цаг хүртэл тасралтгүй ажиллахад хүний нөөц, вакцины нөөц, үйл ажиллагаа, зохион байгуулалтад хяналт тавих